



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 03 өдөр

Дугаар 4/66

Булган сум

Хөрөнгө бүртгэлд авах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.6, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2 дахь заалт, Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны "Төрийн болон орон нутгийн өмчид хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Байгаль хамгаалах сан, Орон нутгийн хөгжлийн сан, Авто замын сангийн хөрөнгөөр 2024 онд ашиглалтад орсон барилга байгууламж, хатуу хучилттай авто зам, засвар шинэчлэлтийн ажлыг данс бүртгэлд авах 2,204,408,163 (хоёр тэрбум хоёр зуун дөрвөн сая дөрвөн зуун найман мянга нэг зуун жаран гурав) төгрөгийн хөрөнгийг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтаар баталсан хөрөнгийг сум, байгууллагын данс бүртгэлд авч, 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд тусгаж тайлагнахыг сумдын Засаг дарга, байгууллагын дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.

3.Энэхүү захирамжийн биелэлтэд хяналт тавьж, 2024 оны жилийн эцсийн үндсэн хөрөнгийн хөдлөл өөрчлөлтийн тайланг Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газартай тооцоо нийлж баталгаажуулахыг Орон нутгийн өмчийн газрын дарга (Т.Баттулга)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Д.ПҮРЭВ-ОЧИР

Аймгийн Засаг даргын 2025 оны
02. дугаар сарын 05-ны/ний өдрийн... дүгээр
захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ДАНС БҮРТГЭЛД АВАХ
ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ

д/д	Хөрөнгийн нэр	Үнийн дүн	Ашиглалтанд хүлээн авах сум байгууллага	Гүйцэтгэгч компани	Хөрөнгийн эх үүсвэр
1	2	3	4	5	6
1	Баян-Агт сумын төвийн Цахилгаан хангамж засвар, шинэчлэлтийн ажил	105,121,322	Баян-Агт сумын ЗДТГ	"БОШГОЛСОН" ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
2	Баян-Агт сумын төвийн Ариутгах татуургын угсралтын ажил	281,108,000	Баян-Агт сумын ЗДТГ	"Эрин гүрэн" ХХК	Байгаль хамгаалах
3	Булган сумын Цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын засвар шинэчлэлт угсралтын ажил	299,497,601	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги	"Өвөлжөөн булаг" ХХК	Орон нутгийн хөгжлийн сан
4	Булган сумын Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын барилгын засварын ажил	198,101,696	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги	"Соотон чоно" ХХК	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
5	Хутаг-Өндөр сумын ЭМТ-ийн фасадны засвар	94,116,474	Хутаг-Өндөр сумын ЭМТ	"Ланд Арч" ХХК	Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт
6	Хутаг-Өндөр сумын төвийн гэрэлтүүлэг	99,693,750	Хутаг-Өндөр сумын ЗДТГ	"Анд-Энерги" ХХК	
7	Хутаг-Өндөр сумын хатуу хучилттай авто зам гэрэлтүүлэг	530,238,823	Хутаг-Өндөр сумын ЗДТГ	"Энх- Алтаргана" ХХК	Улсын төсвийн хөрөнгө оруулалт
8	Булган сумын Авто замын гэрлэн дохио (ОБГ-ын уулзвар)	80,830,497	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги	"ГЭГЭЭН ЦАЙДАМ" ХХК	Авто замын сан
9	Булган сумын Хүүхэд залуучуудын соёл амралтын цэцэрлэгт хүрээлэнгийн тоглоомын барилгын засварын ажил Багц-1	515,700,000	Булган сумын Тохижилт үйлчилгээний анги	"Мээжийн хишиг" ХХК	Байгаль хамгаалах сан
Хөрөнгийн нийт дүн		2,204,408,163			